

СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

2017-12-10

Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	Арга хэмжээ ний дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая тагнаг/	Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ эх үүсвэр/		Хэрэгжилтийн хувь
						Он		
						Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	
Нийгмийн бодлого								
1.1 Боловсрол								
1.1.1 Бүх шатны боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	Тэргүүлэх чиглэлийн судлагдахууныг тодорхойлж сум, орон нутгийн онцлогийг тусгасан чиглэлийг хэрэгжүүлэх	2020	Сумын ЗДТГ, БСУГ, Сургууль, цэцэрлэг,		Монгол хэл, гадаад хэл, математик, байгалийн ухааны хичээл тус бүрээр чиглэл боловсруулж хэрэгжүүлсэн байна.	2025 онд хос бичигтэн болохтой холбогдуулан Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан Булган сумын ЗДТГ, БСУГ-аар, Аймгийн төв номын сан хамтран Булган сумын Засаг даргын нэрэмжит “Үндэсний бичиг-Бидний бахархал”сэдэвт монгол бичгийн тэмцээнийг зохион байгуулж иргэдийн монгол бичгийн боловсролыг нэмэгдүүллээ. Мөн аймгийн БСУГ-тай хамтран бийрэн бичгийн сургалтыг зохион байгуулж 10 гаруй иргэнийг хамруулан сургалаа. Байгалийн ухааны чиглэлээр сургуулиуд туршилтын талбай байгуулан хүүхэд бодит орчинд сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэн хичээл сургалтын үйл ажиллагааг явуулж байгаа ба гадаад хэлний чиглэлээр ЭӨЦС, 12 жилийн 1 дүгээр бүрэн дунд сургуулиуд Энхтайвны корпусны шугамаар гадаад мэргэжилтэнг урьж ажиллуулж хүүхэд, багшийг хөгжүүлсэн арга хэмжээ болж байна. Мөн Булган	100%

							сумын 150 хүүхдийн хүчин чадалтай 2-р цэцэрлэгийн барилга ашиглалтанд орсон ба 3 дугаар 12 жилийн бүрэн дунд сургуулийг байгалийн ухааны гүнзгийрүүлсэн сургалттай сургууль болгож үйл ажиллагааг эхлүүлэхээр захирлыг томилоод байна.	
2	Жил бүр сумын Засаг даргын нэрэмжит “Монгол хэл”-ний олимпиадыг зохион байгуулах	2016-2020	Сумын ЗДТГ, ЕБС-иуд			Олимпиадын бэлтгэл ажлыг хангаж чанартай зохион байгуулах	2017-2018 оны хичээлийн жилээс эхлэн Булган мээж ОНӨХХК-тай хамтран сумын Засаг даргын нэрэмжит “Эх хэл бичгийн олимпиад”-ыг анги нийтийн олимпиадыг 9-р ангиудын дунд 2 үе шаттай зохион байгуулж байна. Эхний үе шатыг 2-р сард сүүлийн шалгаруулалтыг 5 сард хийхээр уралдаанаа зарлан сургуулиуд олимпиадад бэлтгэж байна.	100%
3	“Оюунлаг Булган”, “Амжилтын галт тэрэг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2016-2020	Сумын ЗДТГ, сургууль, цэцэрлэг, БСУГ			Багш нарын идэвх санаачилга, хариуцлага нэмэгдэж ажлын үр дүн сайжирна, суралцагчдын сурлагын чанар дээшилсэн байна.	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн дэд хөтөлбөр “Оюунлаг Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар байгуулан төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа бөгөөд сургууль, цэцэрлэгүүдэд шатрын дугуйланг бага, дунд, ахлах ангийн түвшингээр хичээллүүлж цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд “Цодгор хүү” тэмцээнийг, багш, ажилтан албан хаагч, эцэг эхчүүдийн дунд аварга шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгуулан аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцууллаа. Мөн хөтөлбөрийн хүрээнд	100%

							<p>мэтгэлцээний клубыг сургуулиудад байгуулан сургагч багш нарыг бэлтгэх үйл ажиллагааг явуулж, аймгийн мэтгэлцээний тэмцээнд ЭӨЦС-иас 3 баг оролцон 1 баг 2-р байр эзлэн улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон байна. Үүнээс гадна хүүхдийн оюуны хөгжлийг дэмжиж соробан сампингийн дугуйланг хичээллүүлж байна. Мөн 7-р цэцэрлэг “Шатрын өрөө, “Номын өргөө”-г шинээр байгуулан үйл ажиллагаа явуулж байгаа ба Соёлын ордны англи хэлний номын санг монгол номоор фонд баяжилтыг хийж эхлэн ном хандивлах аяныг өрнүүлснээр 200 гаруй монгол номтой болсон ба аймгийн Засаг даргын 1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сүүлийн үеийн уран зохиолын номоор фонд баяжилт хийлээ.</p>	
4	<p>Сургууль, цэцэрлэг тус бүр хүүхэд хөгжлийн танхим ажиллуулах, хичээл ээс гадуурх сургалт хүмүүжлийн ажлыг өргөжүүлж, хүүхэд багачуудын авьяас чадвар, бие бялдар, урлаг гоо зүйн мэдрэмж, техник сэтгэлгээг хөгжүүлэх</p>	2016-2020	Сумын ЗДТГ Сургууль, цэцэрлэг, БСУГ		<p>Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн 80-аас доошгүй хувь нь дугуйлан секцэнд хамрагдсан байна.</p>	<p>Хүүхэд багачуудын бие бялдар, хөгжил урлаг гоо зүй, техник сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор сургуулиудад мэтгэлцээний танхим, цэцэрлэг бүрт хүүхэд хөгжлийн танхим байгуулан ажиллуулж байна. Хүүхдийн бие бялдар, урлаг гоо зүйн мэдрэмж оюун ухааныг хөгжүүлэх зорилгоор сургууль цэцэрлэгүүдэд 20 гаруй төрлийн секц дугуйланг явуулж давхардсан тоогоор нийт сурагчдын 70 гаруй хувийг</p>	100%	

							хамруулан сургаж байна.	
	5	Хичээлээс гадуурх үйл ажиллагааг явуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх	2016-2020	Сумын ЗДТГ, БСУГ, сургууль цэцэрлэг		Хичээлээс гадуурх үйл ажиллагаа тогтмолжсон байна.	12 жилийн 1 дүгээр бүрэн дунд сургуулийн өргөтгөл барилга угсралтын ажил 70 орчим хувьтай баригдаж байгаа ба 12 жилийн 3 дугаар бүрэн дунд сургууль ашиглалтанд орж удирдлага томилогдон хичээл сургалтын үйл ажиллагаа явуулах бэлтгэл ажлыг хангаж байна. Ирэх сараас үйл ажиллагаагаа эхлүүлснээр хүүхдүүд хичээлээс гадуурх сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулах орчин бүрдэж байна.	70%
1.1.2 Багш, боловсон хүчний мэдлэг боловсролыг тасралтгүй дээшлүүлж үе шаттай сургалтуудад хамруулан хүний нөөцийн чадавхийг бэхжүүлнэ.	6	Сургууль, цэцэрлэгийн багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх аймаг, бүс, улсын чанартай сургалтуудад үе шаттай хамруулах	2016-2020	Сумын ЗДТГ, сургууль, цэцэрлэг, БСУГ		Багш нарын мэдлэг боловсрол дээшилсэн байна.	Багш сурган хүмүүжүүлэгчдийн мэдлэг боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тэднийг мэргэшүүлэх зорилгоор багш нарыг урт богино хугацааны сургалтуудад хамруулан ажиллаж байна. Тухайлбал: Энэ хичээлийн жилд багшийн мэргэжил дээшлүүлэх институтын үндсэн сургалтанд 10 дахь жилдээ ажиллаж байгаа 18 мэргэжлийн багшийг /бага анги, математик, хөгжим бүжиг г.м/, БСУГ-аас Монголын хүний нөөцийн ассиосациастай хамтран зохион байгуулсан СӨБ-ын багш мэргэжлийн мэргэшүүлэх сургалтанд цэцэрлэгийн багш нарыг бүрэн хамруулаа. Мөн 3,7 дугаар цэцэрлэгийн эрхлэгч, 6-р цэцэрлэгийн багш арга зүйч, 4-р цэцэрлэгийн арга зүйч боловсролын магистрын сургалтанд хамрагдан суралцаж	100%

							төгссөн.Багш, туслах багш нарын дунд “Багш олимпиад-2017” олимпиад, “Туслах багш 2017” арга хэмжээнүүдийг зохион байгуулсан нь багш нарын мэдлэг боловсролыг тасралтгүй дээшлүүлсэн томоохон арга хэмжээ боллоо. Мөн энэ хичээлийн жилд аймгийн БСУГ-аас зохион байгуулсан сургалтанд багш нар 100 хувь хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлсэн ба Булган сумын 2-р цэцэрлэгийн эрхлэгч Г.Туяа, 4-р цэцэрлэгийн арга зйүч Б.Нансалмаа нар Япон, Солонгос улсад туршлага судлах сургалтанд хамрагдсан байна. ЭӨЦС багшийн ёс зүй, тогтвортой хөгжлийн бодлого, хөдөлмөрийн аюулгүй байдал зэрэг сэдвийн хүрээнд Орхон аймгаас сургагч багш урьж оролцуулан сургалт мэдээллийг хийсэн байна.	
1.1.3 Боловсролын байгууллагуудын материаллаг баазыг нэмэгдүүлж, засвар үйлчилгээг үе шаттай хийж суралцагчдад тэгш хүртээмжтэй суралцах нөхцөл боломжийг нэмэгдүүлнэ.	7	Боловсролын салбарт хүүхдийн сурч боловсрох хэрэгцээ шаардлагад нийцсэн тоглоом наадгай, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, зөөлөн эдлэлээр хангах	2016-2020	Сумын ЗДТГ, сургууль, цэцэрлэг, төсөл хөтөлбөр		Материаллаг бааз нэмэгдэж хичээл сургалтын үйл ажиллагаа явуулах орчин нөхцөл бүрдсэн байна.	Хүүхдийн сурч боловсрох таатай орчин бүрдүүлэх зорилгоор цэцэрлэгүүд хэмнэгдсэн зардлаасаа ангиудад дрож, тоос сорогч, компьютер, принтер зэргийг авч материаллаг баазаа нэмэгдүүллээ. Мөн 1-р цэцэрлэг гаднаа явган зам барих, дээжний хөргөгч авах, 2-р цэцэрлэг гадна болон дотор тохижилт хийх \гал тогооны иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагдсан\, 3-р цэцэрлэг гал тогоондоо засвар үйлчилгээ хийх,	100%

						<p>буузны жигнүүр, хөргөгч вандан авах зэргээр материалаалга баазаа нэмэгдүүлсэн ба 4-р цэцэрлэг өөрсдийн нөөц боломжоор 1-р хоолны тогоо, буузны жигнүүр, бүлгүүдийн ариун цэврийн байгууламжийг шинэчлэн сайжруулсан, аймгийн хөрөнгө оруулалтаар гаднах машины зогсоолыг, ДЗОУБ-ын хөрөнгө оруулалтаар ширээ сандал, шкаф, тавиураар хангах ажлыг хийсэн. Мөн 6-р цэцэрлэг Турк улсын ТИКА төслийн шугамаар 85,0 сая төгрөгний их засвар, ДЗОУБ-ын санхүүжилтээр шкаф, ширээгээр, УИХ-ын гишүүний хөрөнгө оруулалтаар өнгөт принтерээр хангагдсан. 7-р цэцэрлэг хашааныхаа өнгө үзэмжийг сайжруулж, гадна машины зогсоолыг хийсэн, 2 ангийн зөөлөн эдлэл, салбар цэцэрлэгт ариун цэврийн өрөө, 00-ын асуудал, номын өргөө байгуулсан, шатрын өрөөг тохижуулсан. Цэцэрлэг сургуулиуд багш ажилчдын дунд бүтээлч ажил болгон болзолт уралдаануудыг зарлан анги танхим, гадаад дотоод орчноо тохижуулж сургалтын хэрэглэгдэхүүнүүдийг тасралтгүй нэмэгдүүлж, хичээл сургалтын үйл ажиллагаануудыг олон талт сонирхолтой хэлбэрээр хүүхдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хийж байна. Булган сумын сургууль</p>	
--	--	--	--	--	--	---	--

							цэцэрлэгүүдийн хувьд тоглоом наадгай, сургалтын хэрэглэгдэхүүний хангалт 90 хувьтай байна.	
	8	2-р цэцэрлэг, 640 хүүхдийн шинэ сургуулийн барилга болон 1-р сургуулийн өргөтгөлийг ашиглалтанд оруулах	2016-2020	Сумын ЗДТГ, БСУГ, сургууль цэцэрлэг		Дуусаагүй байгаа барилгууд ашиглалтанд бүрэн орсон байна.	Булган сумын 2-р цэцэрлэгийн барилга ашиглах боломжгүй болж шинэ барилга баригдаж эхлэн нэлээд удаашралтай явсан бол энэ онд ашиглалтанд оруулан 150 хүүхэд хүлээн авах хүчин чадалтайгаар хэвийн үйл ажиллагаагаа явуулж байна. Харин 12 жилийн 1 дүгээр бүрэн дунд сургуулийн өргөтгөл, онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ажил хийгдсэн ба 640 хүүхдийн хүчин чадалтай шинэ сургуулийн барилга ашиглалтанд орж улсын комисс хүлээж авлаа.	100%
	9	3-р цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 4, 6-р цэцэрлэг, 7-р цэцэрлэгийн харьяа цэцэрлэгийн барилгад их засвар хийх	2016-2020	Сумын ЗДТГ, БСУГ, сургууль цэцэрлэг		Их засвар өртгөтгөлийн ажил хийгдсэн байна.	3-р цэцэрлэгийн өргөтгөлийн зургийн даалгаврыг боловсруулж байна. Мөн 1-р багт Катар сангийн хөрөнгө оруулалтаар шинэ 5-р цэцэрлэг баригдахаар төлөвлөгдөн зураг төсөв, газрын асуудлууд шийдэгдээд байна.	40%
1.1.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд иргэдийг бүх шатны боловсролд хамруулж, насан туршийн боловсролын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулна.	10	Сургууль, цэцэрлэгт хамрагдах боломжтой хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суурь судалгаатай болох	2016-2020	Сумын ЗДТГ, сургууль, цэцэрлэг		Суурь судалгаатай болсон байна.	Хөгжлийн бэрхшээлтэй 50 гаруй хүүхдийн суурь судалгаатай болж сургууль цэцэрлэгт хамруулах арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Энэ хичээлийн жилд цэцэрлэгт 2, ЕБС-д 2 хүүхдийг хамруулан сургалаа.	100%
	11	Хөгжлийн бэрхшээлтэй суралцах боломжтой хүүхэд, насанд хүрэгчдийг	2016-2020	Сумын ЗДТГ, БСУГ, ЕБС		Иргэдийн боловсролын түвшин дээшилсэн байна.	Сургууль цэцэрлэг бүр тойргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгааг гаргаж нөхөн боловсрол олгох арга	70%

		бүх шатны боловсролд хамруулах замаар нийгэмшүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэн, өөрсдийн чадамжинд суурилсан сонирхолтой ажлуудыг зохион байгуулах					хэмжээг авч ажиллан энэ хичээлийн жилд цэцэрлэгт хамрагдаагүй байсан 2 хүүхдийг цэцэрлэгт хамруулан сургуулийн өмнөх боловсрол олгосон ба АББ-ын холимогт бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй 5 хүнийг хамрууллаа.	
12		Насан туршийн боловсролын үйл ажиллагааг тогтмолжуулж, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалт мэдээллийг чанартай зохион байгуулах	2016-2020	Сумын ЗДТГ, БСУГ, ЕБС		Иргэдийн боловсролын түвшин дээшилж сургалт мэдээллийн ажил тогтмол чанартай явагдсан байна.	Аймгийн Засаг даргын захирамжаар насан туршийн боловсролын төвийг байгуулж БСУГ-ыг түшиглэн 3 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Энэ онд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран онд хууль эрх зүйн 4, эрүүл мэндийн боловсрол олгох 5, мэргэжлийн чиг баримжаа олгох 1 сургалт, эрүүл аж төрөх эрүүл зан үйл төлөвшүүлэх 2 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Мөн 12 жилийн 1 дүгээр бүрэн дунд сургууль дээр дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд 29 суралцагчтайгаар энэ хичээлийн жилд хичээл сургалтын үйл ажиллагааг явуулж суурь боловсрол 5 иргэнд, бага боловсролыг 10 иргэнд олгож төгсгөлөө. 2017-2018 оны хичээлийн жилд судалгаа бүртгэлд үндэслэн 25 суралцагчтай хичээллэж байна..	100%
13		Сургууль завсардсан хүүхдийн мэдээлэл, судалгааг гаргаж,	2016-2020	Сумын ЗДТГ, БСУГ, сургууль цэцэрлэг		Хүүхэд бүр сурч хүмүүжих боломжтой болно.	Сургууль завсардсан болон нөхөн боловсрол эзэмших шаардлагатай иргэдийн судалгааг гаргаж 2016-2017 оны хичээлийн жилд 8	100%

		нөхөн боловсрол олгох					иргэнийг, 2017-2018 оны хичээлийн жилд мөн 5 иргэнийг дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд хамруулж байна.	
Соёл урлаг								
1.2.1 Соёл урлагийн байгууллагын материаллаг баазыг нэмэгдүүлж, мэргэжлийн боловсон хүчнээр ханган мэдлэг боловсролыг тасралтгүй дээшлүүлж, хүн амд урлаг, соёлын бүх үйлчилгээг жигд хүргэнэ.	14	Соёлын төвийн бүтэц орон тоог жил бүр нэмэгдүүлж ордны жишигт хүргэх	2016-2020	Сумын ЗДТГ, БСУГ, Соёлын ордон		Ажлын байр нэмэгдэхийн зэрэгцээ соёлын ордны үйл ажиллагаа өргөжнө.	Соёлын төвийг соёлын ордны бүтэц орон тоотой ажиллах хүчнийг ажиллуулах саналыг холбогдох байгууллагуудад саналаа хүргүүлэн ажилласнаар 2018 оны төсөвт цалингийн санд 1,0 сая төгрөгийг нэмж тусгуулсан. Мөн Соёлын төв өөрсдийн давсан орлогоос морин хуурийн багшийн урамшууллыг шийдвэрлэн ажиллуулж байна.	70%
	15	Ажилтан албан хаагчдын мэдлэг боловсролыг тогтвортой дээшлүүлэх, уран бүтээлчдийн нөөц бэлтгэж, сургах	2016-2020	Сумын ЗДТГ, БСУГ, Соёлын ордон		Мэдлэг боловсрол нэмэгдэж иргэдэд хүргэх соёлын үйлчилгээ чанаржина.	Соёлын ажилтнуудыг чадавхижуулах сургалтанд хамруулан мэргэжил боловсролыг дээшлүүлж тасралтгүй дээшлүүлж байна. 2016 онд соёлын ордны эрхлэгч удирдах ажилтны сургалтанд 2 удаа, ажилтан Ганзориг, Маралмаа нар 2 удаа, 2017 онд мөн эрхлэгч 1 удаа, номын санч Маралмаа номын санчийн сургалтанд хамрагдан мэдлэг боловсролоо дээшлүүллээ. Мөн соёлын ордны эрхлэгч, хөгжмийн багш Улаан Үүд хотод туршлага судалж хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн ба Соёлын ордон мэргэжлийн уран бүтээлчдийг бэлтгэж сургах тал дээр ОХУ-ын Улаан үүд хотын багшийн коллежтой хамтран 2015-2016 оны хичээлийн жилд 8 оюутан сургаж байсан бол 2016-2017	100%

							оны хичээлийн жилд 15 оюутныг нэмж элсүүлж хөгжмийн багшийн ангид 19, биеийн тамирын багшийн ангид 2, зураг дизайны ангид 2 оюутныг суралцуулж бэлтгэж байна.	
1.2.2 Ардын авъяастан, соёлын өвийг өвлөн тээгч, билэг авьяастнуудын санал санаачлагыг дэмжин тэдэнтэй хамтран иргэдэд үзүүлэх урлаг, соёлын үйлчилгээг нэмэгдүүлнэ	16	Уртын дуу, Морин хуур хөтөлбөрийг хэрэгжүүлж уран нугаралтыг сурталчилах, түгээн дэлгэрүүлэх	2016-2020	Сумын ЗДТГ, БСУГ, Соёлын ордон		Морин хуур, уртын дуу, уран нугаралтаар хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байна.	“Уртын дуу, Морин хуур” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсгийг байгуулан төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж суманд 1, сургууль тус бүрт 1 багш уртын дууны сургагч багшаар бэлтгэн хичээл сургалтын үйл ажиллагаануудыг явуулж байна. Энэ онд аймгийн Соёлын ордон дээр уртын дууны сургагч багшаар Долгорсүрэнтэй гэрээ байгуулан сургалтыг эхлүүлж одоогийн байдлаар 9 хүнийг сургаж байна. Мөн “Булган хотын хавар” урлагийн наадамд шинэ ардын авьяастнуудыг нээн илрүүлэх зорилгоор морин хуур уртын дууг тодорхой 1 шалгуур болгон оруулсан нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөөцөө бүрдүүлсэн томоохон арга хэмжээ боллоо. Энэ онд аймгийн “Ардын урлагийн наадам”-д оролцох ардын авьяастнуудын бэлтгэл сургуулилтыг сайтар хийж оролцуулснаас “Уртын дуу”-ны төрөлд ЭӨЦС-ийн багш Х.Мөнхбаатар 1-р байр, морин хуурын төрөлд ЭӨЦС-ийн хамтлаг тэргүүн байрыг эзэлсэн амжилттай оролцож	100%

						<p>нийлбэр дүнгээр Булган сум тэргүүлэн цомын эзэн боллоо.“Уран нугаралт”-ыг сурталчлан, дэлгэрүүлэх ажлыг эхлүүлжХөтөл тосгоны “Нарны охид” уран нугаралтын клубын багш Э.Түмэнжаргалыг урьж 25 нугараач хүүхэдтэйгээр хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлж өнөөдрийг хүртэл маш амжилттай хичээллэж байна. Сургалт эхэлсэнээс хойш сурагчид маань “Талын шувуу”, “Бурхад”, “Гурвал”, “Шанз” зэрэг нугаралтын үзүүлбэрийг сурч олон нийтэд хүргээд байна. Мөн Соёлын ордноос зохион байгуулсан 10 тоглолт, 5 үйл ажиллагаанд уран бүтээлийн дээжийг өргөн барьсан байна.Өнгөрсөн 10 сард нугараачид Дундговь аймагт болсон өсвөрийн циркчдийн улсын уралдаанд амжилттай оролцож тусгай байр эзэлсэн амжилттай ажиллаж байна.</p>	
17	Амьд хөгжмийг сурталчилах, дэлгэрүүлэх	2016-2020	Сумын ЗДТГ, Соёлын ордон	Амьд хөгжим суралцагчдын тоо, хамтлаг нэмэгдсэн байна.	Амьд хөгжмийн дугуйланг Соёлын ордныг түшиглэн хичээллүүлж байна. Одоогийн байдлаар 16 суралцагчтай бэлтгэл сургуулилтыг хийхээс гадна амьд хөгжмийг иргэдэд сурталчилан 23 төрлийн арга хэмжээг оролцлоо. Сум төдийгүй аймгийн хэмжээнд амьд хөгжмийг сурталчилан түгээн дэлгэрүүлэх зорилгоор Хялганат тосгонд сургалт зохион байгуулж 18 хүүхдийн бүрэлдэхүүнтэй 3 хамтлагийг шинээр байгуулахад дэмжлэг	100%	

						үзүүлэн хамтран ажиллалаа. Мөн Булган аймгийн ЦГ, ОБГ-ын дэргэд цахилгаан хөгжмийн хамтлагуудыг байгуулан арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.	
18	Ардын урлагийн наадмыг 2 жил тутамд зохион байгуулах	2016-2020	Сумын ЗДТГ, Соёлын ордон		Үндэсний өв соёлыг хадгалсан ардын авьяастнуудыг бэлтгэгдэнэ.	Булган хотын хавар урлагийн наадмыг зохион байгуулж ардын авьяастнуудыг нээн илрүүлэх хөгжүүлэх түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ авч ажилласан. Урлагийн наадмаас шалгарсан ардын авьяастнуудын бэлтгэл сургуулилтыг сайтар хийж оролцуулснаас “Уртын дуу”-ны төрөлд ЭӨЦС-ийн багш Х.Мөнхбаатар 1-р байр, морин хуурын төрөлд ЭӨЦС-ийн хамтлаг тэргүүн байрыг эзэлсэн амжилттай оролцож нийлбэр дүнгээр Булган сум тэргүүлэн цомын эзэн боллоо.	100%
19	“Булганы хавар” соёлын арга хэмжээг жил бүр зохион байгуулах	2016-2020	Сумын ЗДТГ, Соёлын ордон		Сумын хэмжээнд иргэдэд хүрэх соёлын үйлчилгээ сайжирч, иргэдийн оролцоо нэмэгдсэн байна.	Иргэдэд хавар цагийн соёл урлагийн арга хэмжээг шинэлэг хэлбэрээр хүргэх иргэдийн авьяас чадварыг нээн илрүүлэх соёлын биет өвийг сэргээн хөгжүүлэх зорилгоор “Булган хотын хавар” урлагийн наадмыг анх удаа санаачлан зохион байгуулж төр хувийн хэвшлийн 23 байгууллагын 600 гаруй ардын авьяастнуудыг оролцуулж шилдгүүдийг шалгаруулан олон олон шинэ авьяастнуудыг нээн илрүүлсэн томоохон арга хэмжээ боллоо. Уг наадамд тэргүүн байранд ЭӨЦС, дэд байранд цагдаагийн газар, гутгаар байранд 12 жилийн 1-р бүрэн дунд сургууль,	100%

							тусгай байрыг Төрийн банк, Хужирт баг, Булган хангай МСҮТ тус тус эзэллээ.	
1.2.3 Соёлын ордоны музейн үзмэр, номын фондын баяжилтыг нэмэгдүүлж, интернетийн орчныг сайжруулан үйл ажиллагааг өргөжүүлнэ.	20	Соёлын ордоны музейн үзмэрийг нэмэгдүүлж баяжуулах	2016-2020	Сумын ЗДТГ, Соёлын ордон		Үзмэрийн тоо нэмэгдсэн байна.	Монгол улсын анхны хурандаа цолтон Бүрэгхангай сумын уугуул 3.Жанцан, Булган аймгийн 4 гавьяат Баасанжав, Саранчимэг, Цолмонбаатар, Очирбат, МУ-ын анхны баавгай сургагчийн хөрөг зургийг байршуулан музейн үзмэрийг баяжууллаа.	100%
	21	Англи хэлний номын санг түшиглэн англи хэлний сургалтуудыг хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдэд явуулах	2016-2020	Сумын ЗДТГ, Соёлын ордон		Сургалтын үйл ажиллагаа тогтмолжиж иргэдийн англи хэлний боловсролын түвшин нэмэгдсэн байна.	Сумын Соёлын ордны англи хэлний номын санг түшиглэн англи хэлний сургалтыг зохион байгуулан тэдний хэлний мэдлэгийн боловсролыг нэмэгдүүлж ажиллалаа. Сургалтанд 25 хүүхэд, 10 гаруй насанд хүрэгчид хамрагдлаа.	100%
Эрүүл мэнд								
1.3.1 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ	22	Сар бүрийг тодорхой сэдвээр эрүүл мэндийн сарын аян зарлаж сургалт мэдээлэл тогтмол хийх	2016-2020	Сумын ЗДТГ, ӨЭМТ, ЭМГ		Нийт иргэдийн 30 хувийг сургалт мэдээлэлд хамруулсан байна.	Аймгийн Засаг даргын захирамжаар сар бүрийг “Нэрэмжит сар”-ын ажил болгон зарласантай холбогдуулан сумын хэмжээнд төлөвлөгөө боловсруулан холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.	100%
	23	Эрүүл мэндийн сайн дурын туслагч нарын үйл ажиллагааг идэвхжүүлж, иргэдэд хүргэх эрүүл мэндийн зөвлөмж мэдээллийг нэмэгдүүлэх	2016-2020	Сумын ЗДТГ, ӨЭМТ, ЭМГ		Иргэдийн эрүүл мэндийн мэдлэг дээшилсэн байна.	Иргэдэд хүрэх эрүүл мэндийн боловсрол олгох тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор эрүүл мэндийн сайн дурын туслагч нарыг бэлтгэж тэднийг мэдээ мэдээллээр хангаж мэдлэг боловсролыг тогтмол дээшлүүлэх зорилгоор улирал бүр чадавхижуулах сургалтуудыг хийхээр төлөвлөн 3 удаагийн сургалтанд хамруулаад	70%

							байна. Энэ оны 1-р улиралд эрүүл мэндийн сайн дурын туслагч нарт айл өрхийнхөө судалгаа мэдээллийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хавтас хэрэгсэл, гарын авлага зөвлөмжүүдээр хангаж халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, идэвхтэй хөдөлгөөний ач тус, ундны усны эрүүл ахуй зэрэг сэдвүүдээр аймгийн ЭМГ-тай хамтран мэдээлэл ярилцлага хийсэн. Мөн 2,3 дугаар улиралд аймгийн ЭМГ-тай хамтран 2 удаагийн сургалт мэдээллийг хийж гарын авлага зөвлөмжөөр ханган ажиллалаа.	
1.3.2 Хөдөөгийн багийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж урьдчилан сэргийлэх үзлэг болон дархлаажуулалтыг нэмэгдүүлнэ.	24		2016-2020		ЭМГ, ӨЭМТ, НЭ	Эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдсэн байна.	Хавдаргүй Булган аяны хүрээнд хавдрын нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг оношлогоог ӨЭМТ-үүдэд хийж 3240 иргэнийг хамруулан В вирусээс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 500 хүнд хийсэн байна. Мөн Цоожэд ӨЭМТ нь АНЭ-ийн дотор, мэдрэл, нүд, арьс өнгө, хүүхэд, эмэгтэйчүүдийн эмч нартай хамтран харъяа багийн иргэдэд нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг 131 иргэнд хийж эрүүл мэнийн тусламж үйлчилгээг хүргэлээ. Мөн аймгийн НЭ Орхон аймагт байрлах Медипас бүсийн оношлогооны төвтэй хамтран зохион байгуулсан болон “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд Цогтхунтайжийн талбайд	100%

							зохион байгуулагдсан 2 удаагийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт иргэдээ хамруулах тал дээр хамтран ажиллаж үзлэг оношлогоонд хамрууллаа.	
	25	Халдварт бус өвчний илрүүлэг үзлэгт зорилтот бүлгийн хүмүүсийг хамруулах ажлыг эрчимжүүлэх	2016-2020	ЭМГ, ӨЭМТ, НЭ		Эрт илрүүлэг үзлэгийн хувь нэмэгдсэн байна.	Артерийн даралт ихсэлт, чихрийн шижин хэв шинж 2, хөх, умайн хүзүүний өмөн, элэгний хавдраас урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог зорилтот насны иргэдэд олон талт хэлбэрээр хийлээ. Үүнд: Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд үзлэг оношилгоог хийхээс гадна байгууллагуудаар явж ажлын байранд нь үзлэгийг хийх, мөн зорилтот бүлгийн иргэдэд урилга хүргүүлж ажилласнаар 2017 онд халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэг артерийн гипертензи, чихрийн шижингийн үзлэг 58,3 хувь, умайн хүзүүний өмөн, хөхний өмөнгийн үзлэг 29 хувьтай хамрагдсан ба урд оны мөн үетэй харьцуулахад өссөн үзлэгийн хувь өссөн.	70%
1.3.3 Мэргэжлийн байгууллагатай хамтран эмч, эмнэлгийн ажилтны хангамжийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн төвүүдийн материаллаг баазыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ	26	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шаардлагатай эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах	2016-2020	Сумын ЗДТГ, ЭМГ,ӨЭМТ		Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг судлаж байна.	0%
	27	Эмийн цэцэглэн ӨЭМТ-ийг түргэн тусламжийн авто машинаар хангах болон өргөтгөлийн барилгыг ашиглалтанд оруулах	2016-2020	Сумын ЗДТГ, ЭМГ,ӨЭМТ		Автомашинaar хангагдсан байна.	Хугацаа болоогүй.	
Биеийн тамир, спорт								

1.4.1 Нийтийн биеийн тамираар хичээллэх орчин бүрдүүлж идэвхтэй дасгал хөдөлгөөнийг амьдралын хэв маяг болгон хэвшүүлнэ.	28	Олон төрөлт дасгал хөдөлгөөний ач холбогдлын талаар сургалт сурталчилгаа хийж, баг бүрт иргэдийг дасгал хөдөлгөөн хийлгэж хэвшүүлэх	2016-2020	Сумын ЗДТГ, ӨЭМТ, БТСГ	Халдварт бус өвчний тохиолдол буурсан байна.	Сумын ИТХ-аар батлан хэрэгжүүлж буй “Ахмадуудын эрүүл мэнд идэвхтэй хөдөлгөөн” урт хугацааны хөтөлбөрийн хүрээнд ахмадууд хийн дасгалыг хийж баг бүрдүүлээд сар бүрийн 28-нд Цогтхунтайжийн талбайд дасгал хийж хэвшсэн. Цаашид үйл ажиллагааг эрчимжүүлэн баг бүр дасгал хөдөлгөөнийг хийж хэвшүүлэхээр ажлаа эхлүүлээд байна. Идэвхтэй хөдөлгөөний ач тус сэдвээр иргэдэд сургалт мэдээллийг ахмадуудад 1 удаа хийсэн ба аймгийн төвд байрлах LED дэлгэцээр шторк мэдээлэл явуулж сурталчилан ажиллалаа. Мөн Соёлын ордонд сар бүрийн 3,15-нд “Ахмадын дуулах бүжиглэх өдөр”-ийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж хэвшсэн ба ойролцоо аймаг, сумын ахмадууд ирж оролцон үйл ажиллагаа өргөжиж байна. Энэ онд сумын ОНХС-ийн 10 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1,2,3,5 дугаар багуудад хүүхдийн тоглоомын талбай бүхий сагсан бөмбөгийн талбайг байгуулж хүүхэд өсвөр үе, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, дасгал хөдөлгөөн хийх орчин нөхцөлийг бүрдүүллээ.	70%
	29	Ногоон байгууламж бүхий явган алхалт, гүйлтийн зам талбай, хөл бөмбөг, мөсөн гулгуурын талбай байгуулах	2016-2020	Сумын ЗДТГ, БТСГ	Нийтийн биеийн тамирын талбай баг, сургуулийг түшиглэн бий болсон байна.	Өвлийн спортыг дэмжиж мөсөн гулгуурын талбайг жил бүр аймгийн БТСГ-тай хамтран байгуулж 2017 онд сумын Засаг даргын нэрэмжит “Өсвөр үеийн аварга шалгаруулах тэшүүрийн тамцээн”-ийг амжилттай зохион байгуулж	70%

							багийн дүнгээр ЭӨЦС –ийн баг тамирчид тэргүүн байрыг эзэлсэн. Мөн Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнд мөсөн гулгуурын талбай байгуулж иргэд чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх улмаар биеийн тамираар хичээллэх орчин бүрдүүлээ.	
1.4.2 Улсын чанартай тэмцээн уралдаанд оролцох баг, тамирчдад дэмжлэг үзүүлж тэднийг сурталчлах алдаршуулах, нэрэмжит тэмцээн уралдааныг орон нутагт зохион байгуулна.	30		2016-2020			Өсвөр үе, насанд хүрэгчдийн дунд тэмцээн уралдааныг зохион байгуулалт сайтай хийж иргэдийн оролцоог нэмэгдүүлэн аварга багуудыг шалгаруулсан байна.	Булган хотын аварга шалгаруулах гар бөмбөг, сагсан бөмбөгийн тэмцээнийг өсвөр үе, насанд хүрэгчдийн дунд зохион байгуулах	70%

							бэлтгэн оролцуулж, 4 мөнгөн медалийг хүртсэн байна. Мөн ахмадын сумын аварга шалгаруулах шилжин явах цом бүхий гар бөмбөгийн тэмцээн, Булган сумын харьяа байгууллагуудын үйлчилгээний ажилтан албан хаагчдын дунд аварга шалгаруулах “Гар бөмбөг”-ийн тэмцээнийг амжилттай зохион байгуулж аваргуудаа тодрууллаа.	
	31	Улс, олон улсын чанартай тэмцээнд сум орон нутгаа төлөөлөн оролцох тамирчдад дэмжлэг үзүүлэх, тэднийг алдаршуулах, сурталчлах	2016-2020	Сумын ЗДТГ, ЕБС, БТСГ		Материаллаг болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.	Боксын улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдыг бэлтгэлээ хангахад нь эд зүйлийн дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. Мөн хөнгөн атлетийн чиглэлээр амжилт гаргаж буй 1-р багийн иргэн н.Бат-Эрдэнэд 1.0 сая, Гал унтраах арга техникийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан н. Мөнхтунгалагт 300.0 мянган төгрөгийн дэмжлэгийн асуудлыг аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлээ.	100%
1.4.3 Үндэсний хэв шинжийг агуулсан спортын төрлийг дэмжинэ.	32	Шагайн болон сур харвааг иргэдэд сурталчлан таниулах уралдаан тэмцээнийг зохион байгуулах	2016-2020	Сумын ЗДТГ БТСГ		Үндэсний спортын төрөл хөгжих боломж бүрдэнэ	Монгол нум сум аймгийн дэд хөтөлбөр хэрэгжиж байгаатай холбогдуулан ЕБС-иуд дээр нум сумны гарал үүсэл, харвах арга барилд сургах сургалтууд мэдээллийг хийж эхэлсэн байна. Мөн сур харваж сурах сонирхолтой иргэдийн судалгааг авч бүртгэн сургалт явуулж 26 иргэнийг хамруулан сургалаа. Үүнээс гадна шагай харвааг хөгжүүлэх зорилгоор Булган сумын ЗДТГ-т “Мээрэн” багийг байгуулан тэднээр дамжуулан иргэдэд сурталчилан түгээн дэлгэрүүлэх ажлыг хийж	100%

							байна. “Мээрэн” баг маань байгуулагдсанаар 2016 онд Булган сумын Засаг даргын нэрэмжит шагайн харвааны тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Мөн зохион байгуулагдсан тэмцээн уралдаануудад сум орон нутгийг төлөөлөн оролцсоноор шинэ залуу харваачдыг олноор нэмэгдүүлж байна. Энэ онд аймгийн шагайн холбоотой хамтран Булган сумын 1-р багт байрлах Бурхан багшийн энергийн цэцэрлэгт хүрээлэнд сумын ЗДТГ-ын “Мээрэн” багийн нэрэмжит “Шагайн тойром” харвааг зохион байгуулж нийт 13 баг тамирчид оролцож тэргүүн байрыг Түвшинжаргал ахлагчтай “Илчит металл” ХХК-ны баг, 2-р байрыг Баясгалан ахлагчтай “Сэлэнгэ пресс” ХХК-ны баг, 3-р байрыг М.Лхагвадорж ахлагчтай “Мээрэн” баг эзэллээ. Мөн аймгийн нум сумын холбоотой хамтран “Отог сурын харваа” аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа.	
--	--	--	--	--	--	--	--	--

1.5 Хүн ам, хөдөлмөр эрхлэлт

1.5.1.Ажлын байрны хангамжийг сайжруулах замаар гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулж хүн амын өсөлтийг нэмэгдүүлнэ.	33	Сул чөлөөтэй ажлын байр болон ажил хайгч иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн санд бүртгэж түр болон байнгын ажлын байранд зуучилж ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх	2017-2020	ХХҮГ, Булган сум ЗДТГ		Ажил хайгч иргэдийн 10%-ийг ажлын байраар хангасан байх	Шинэ ажлын байр 472, үүнээс байнгын ажлын байранд 156 иргэн, улирлын ажлын байранд 181 иргэн, түр ажлын байранд 133 иргэнийг ажлын байраар ханган ажиллахаас гадна Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд бий болсон ажлын байрыг бүртгэж ажиллалаа.	100%
	34	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын арга	2017-2020	ХХҮГ, Булган сум ЗДТГ		Ажилгүйдлийн түвшин тодорхой	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд Амьжиргааны баталгаажих	40%

		хэмжээтэй нягт уялдуулан ажлын байрыг тууштай нэмэгдүүлж, ажил хайгч иргэдийн 5-10 хувийг түр болон байнгын ажлын байраар хангах				хувиар буурна.	түвшингээс доогуур орлоготой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор нийтийг хамарсан ажилд Булган сумын ЗДТГ, Тохижилт үйлчилгээний ангиас хэрэгжүүлсэн 6 төсөлд давхардсан тоогоор нийт 66 иргэнийг хамруулсан. Нэмэлтээр Тохижилт үйлчилгээний ангиас хийж гүйцэтгэхээр “Цас-2017” төслийн хүрээнд авто замын дагтаршсан цас цэвэрлэх ажилд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 40 иргэнийг авч ажиллуулж байна.	
35		Хөдөлмөрийн яармаг, өдөрлөг, үзэсгэлэн, нээлттэй хаалганы өдөр зэрэг үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, хөдөлмөрийн зах зээлд дэмжлэг үзүүлэх	2017-2020	ХХҮГ, Булган сум ЗДТГ		Өрхийн болон үйлдвэрлэлийн орлого нэмэгдсэн байна.	Орон нутагт үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй аж ахуй нэгж байгууллага, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, сум хөгжүүлэх сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авсан хувиараа эрхлэгч иргэдийн үйл ажиллагааг сурталчлах, худалдан борлуулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор “ ХАЛАМЖИЙГ ХӨДӨЛМӨР БОЛГОЁ ” хөдөлмөрийн яармаг, үзэсгэлэн худалдааг 2017 оны 11 дүгээр сарын 3,4-ны өдөр Булган сумын Спортын ордонд амжилттай зохион байгууллаа.	100%
36		Иргэний бүртгэл, мэдээллийн сангийн баяжилтыг тухай бүр хийж, хаягийн зөрчлийг бүрэн арилгана	2017-2020	ХХҮГ, Булган сум ЗДТГ		Иргэний бүртгэл, мэдээлэл үнэн зөв болно.	Булган сумын иргэний улсын бүртгэл нь 2017 оны байдлаар дараах бүртгэлийг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: Төрөлтийн бүртгэл-234, Үрчлэлт-13, Овог нэр өөрчлөлт- 31, Эцэг тогтоолт-107, Гэрлэлт-70, Гэрлэлт	100%

							цуцлалт-23, Нас баралт -76, Аймаг нийслэл рүү шилжин явсан-203 иргэн, Аймаг нийслэлээс шилжин ирсэн-153 иргэн, сум болон баг хоорондын шилжин ирсэн болон явсан-327иргэн, иргэний үнэмлэх шинээр захиалсан-117 иргэн, 25 болон 45 насны сунгалт-328 иргэн, хаяж гээгдүүлсэн, үрэгдүүлсэн-272 иргэн иргэний үнэмлэхээ захиалан хүлээн авсан байна.	
1.5.2 Орон нутгийн зах зээлийг өргөтгөх, хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээлийг нэмэгдүүлэн ядуурлыг бууруулахад чиглэгдсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, ажлын байр шинээр бий болгосон ажил олгогч, төсөл хэрэгжүүлэгчидтэй нягт хамтран ажиллана.	37	Сумын хэмжээнд жил бүр тодорхой хэмжээний өрх, иргэнийг ажлын байраар ханган ажилгүйдлийг бууруулж тогтсон орлоготой болгох	2017-2020	ХХҮГ, Булган сум ЗДТГ		Өрхийн аль нэг гишүүнийг ажлын байраар хангаж ажилласан байх	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 5 хөтөлбөрийн “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт 17 иргэнд 28,8 сая төгрөг, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт 4 төгсөгчдөд 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих арга хэмжээний Бизнес санааг хөгжүүлэх, бизнес сэтгэлгээг хөгжүүлэх, бизнес модел хавтан ашиглах сургалтыг зохион байгуулж нийт 6 багийн 55 оролцогч хамрагдаж бизнес санаагаа танилцуулан өрсөлдсөнөөс Р.Ариунзаяа ахлагчтай “Кофе шоп” төслийн багийнхан тэргүүн байр эзлэж дараагийн шатны хөтөлбөр хурдасгуур арга хэмжээнд хамрагдаж 10 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авах эрхтэй болсон.	100%

						<p>“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт 2 малчинд 10,0 сая төгрөг, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт 7 иргэнд 11,6 сая төгрөг, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт 5 иргэнд 5,0 сая төгрөг нийт 35 иргэнд 65,4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн байнгын ажлын байраар ханган ажиллалаа. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 36 иргэнд 9,044,0 төгрөгийн урамшуулалыг олгож түр ажлын байраар ханган ажиллалаа. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор нийтийг хамарсан ажилд Булган сумын ЗДТГ, Тохижилт үйлчилгээний ангиас хэрэгжүүлсэн 6 төсөлд давхардсан тоогоор нийт 66 иргэнд 16800,000 төгрөгний ажиллах хүчний хөлсийг Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас гаргуулан ажиллалаа. Нэмэлтээр Тохижилт үйлчилгээний ангиас хийж гүйцэтгэхээр “Цас-2017” төслийн хүрээнд</p>
--	--	--	--	--	--	---

							авто замын дагтаршсан цас цэвэрлэх ажилд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 40 иргэдийг авч ажиллуулж байна. ХЭДС-ийн жижиг зээлэнд 7 иргэнд 73,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж ажиллалаа. Дээрх төсөл хөтөлбөхүүдийн хүрээнд шинэ ажлын байр 12 сарын 6-ны байдлаар 472, үүнээс байнгын ажлын байр 156, улирлын ажлын байр 181, түр ажлын байр 133 бий болоод байна.	
	38	Ядуурлыг бууруулах олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг орон нутагт идэвхжүүлж, уялдаа холбоог сайжруулах	2017-2020	ХХҮГ, Булган сум ЗДТГ		Ядуурлаас гаргах төсөл хөтөлбөрт 2 өрхийг хамруулсан байна.	ХБМС төвөөс хуримтлалын бүлгийн үйл ажиллагааг дэмжиж орон сууцны нөхцөл сайжруулах төслийг 0,5 сая төгрөгөөр, хашаа гудамж жигдрүүлэх төслийг 2.5 сая төгрөгөөр багуудад хэрэгжүүлсэн.	100%
	39	Өрхийн бичил бизнесийг дэмжих	2017-2020	ХХҮГ, Булган сум ЗДТГ		Жилд 2-3 өрхийн бизнес эрхлэгчийг дэмжсэн байна.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 5 хөтөлбөрүүдийн хүрээнд 25 өрхөд санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажилласан.	100%
1.5.3. Нийгмийн халамжийн зорилтот бүлэг рүү чиглэсэн ажлыг нөхцөл байдалд тохируулан чанартай гүйцэтгэж, хүүхэд хамгаалал, гэр бүлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	40	“Өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-нд АБТДО-той өрхүүдийг хамруулж өөрсдийнх нь оролцоотойгоор амьжиргааг нь дээшлүүлэх ажлуудыг үе шаттай зохион байгуулах	2017-2020	ХХҮГ, Булган сум ЗДТГ		АБТДО-той өрхийн амжиргааг тодорхой хувиар дээшлүүлсэн байх	Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд өрхийн амьжиргааг нь сайжруулах 35 өрхийг сонгон амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж өрхийн гишүүдийг хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөр, нийтийг хамарсан ажил, ажил мэргэжлийн ур чадвар олгох сургалт, ажилд зуулчилах, бусад жижиг зээл, хандив, тусламж, олон нийтийн оролцоонд	70%

							түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөл, хууль эрх зүйн болон амьдрах ухааны сургалт, лекц, хэлэлцүүлэгт хамруулж тэдний нийгмийн идэвхи санаачлагыг өрнүүлэн өрхийн орлогоо нэмэгдүүлэх, амьжиргаагаа өөрчлөх, сэтгэл зүйд нөлөөлөх ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.	
41	Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаагаар босго онооноос доош үнэлэгдсэн өрхийг "Хүнсний эрхийн бичиг"-т хамруулж амьжиргаанд нь дэмжлэг үзүүлэх	2017-2020	ХХҮГ, Булган сум ЗДТГ		1, 2 дугаар түвшний айл өрхийг Хүнсний эрхийн бичигт хамруулсан байна.	Хүнсний эрхийн бичгээр үйлчилэх мэдээллийн санд 3589 өрх бүртгэлтэй үүнээс хүнсний эрхийн бичгийн босго онооноос доогуур түвшинд амьдарч байгаа 146 өрхийн 857 иргэн үүнээс том хүн 459, хүүхэд 398 хамрагдаж 8,5 сая төгрөгний хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэн хоол хүнс тэжээлийн хэрэгцээг хангаж, эрүүл мэндийн даатгалыг төрөөс төлж тэднийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр цаг алдалгүй үйлчилүүлэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.	100%	
42	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус секторт ажиллагчдын эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх.	2017-2020	НДХ, Булган сум ЗДТГ		Эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдалт өснө.	НДХ-тэй хамтарн сургалт мэдээллийн ажлыг малчдад танхимчн болон талбайн хэлбэрээр хүргэж байна. Мөн сайн дурын даатгалыг НДХ-дээр төвлөрч үйл ажиллагаа хийж байна	70%	

3.2.1 Шинээр үүсэххороололболон алслагдсанайл өрхийнэрчим хүчийгнэмэгдүүлжаг аарыншугамболондэ дстанцбарина	103	Хэрэглээний эрчим хүчний уналтыг бууруулах дэд станц барих /6Г, Д хэсэг, домын дэвсэг, /	2017-2020	ХБХ, ЭБЦТС ТӨХК, Сумын ЗДТГ		Хэрэглээний эрчим хүчний уналт буурсан байна.	Дэлхийн банкны санхүүжилтээр хийгдэх 04 ква-ын шугам, тулгуур шинэчлэлийн ажлын зураг төсөвт хэрэглээний эрчим хүч уналттай хэсгүүдэд дэд станц бариулахаар тусгуулсан ба энэ онд 100 ква-ын дэд станцыг 6Д хэсэгт барьж ашиглалтанд оруулсан.	100%
	104	Туслах аж ахуй эрхлэх зориулалттай суурьшлийн бүсийг бий болгож цахилгаан хангамж, ундны усны асуудлыг шийдвэрлэх /Гурилын үйлдвэрийн гахайн байр болон БОАЖГ-ын орчим/	2017-2020	ХБХ, ЭБЦТС ТӨХК, Сумын ЗДТГ		Тооцоо судалгаа хийж хөрөнгө оруулалтыг тооцох	Хугацаа болоогүй	
	105	Шинээр үүсэж буй	2017-	ХБХ, ЭБЦТС		Тооцоо	Хугацаа болоогүй	

		гэр хорооллын цахилгаан хангамж, ундны усны асуудлыг шийдвэрлэх /Майдар голын дэнж болон БОАЖГ-ын орчим/	2020	ТӨХК, Сумын ЗДТГ		судалгаа хийж хөрөнгө оруулалтыг тооцох		
3.2.2 Гудамж, талбай, нийтийн нээмшлийнг эрэлтүүлгийн чанарыг сайжруулжш инээргэрэлтүүлэгтав ихажлыг үргэлжлүүлнэ.	106	Хүн амын урсгал ихтэй гэр хорооллын гудамжуудыг гэрэлтүүлэгтэй болгох	2017-2020	Сумын ЗДТГ, ТҮА		Холбогдох тооцоо, судалгаа, зураг төсвийг хийлгэх	Магсаржав, Дамба, Энэбишийн гудамжны авто замын гэрэлтүүлгийг шинэчлүүлэх саналыг аймгийн 80 жилийн ойн бүтээлч ажлын саналд тусгуулснаар зураг төсөв хийгдэж 477,0 сая төгрөгөөр Шунхлай ШТС орчмоос төв зам дагуу /бага тойрог/ 2 толгой бүхий 2 эгнээ гэрэлтүүлэг тавих ажил хийгдэхээр гүйцэтгэчийг шалгаруулж гэрээг байгуулсан. Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтанд гэр хорооллын гудамжийг гэрэлтүүлэх ажлыг тусгуулсан.	100%
	107	Хотын төвийн гэрэлтүүлгийг дэвшилтэт технологи бүхий гэрэлтүүлгээр шинэчлэх	2017-2020	Сумын ЗДТГ, ТҮА			Эрчим хүчний хэмнэлттэй лэд гэрэлтүүлгийг сонгон зургийн даалгаварт тусгуулан гүйцэтгүүлж байна.	100%
3.3 Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт								
3.3.1 Булган хотыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу эрчимтэй хөгжүүлж, оронсууцны орчиннө хцлийг сайжруулж, хотын тохижилт, соёлжилт, бүтээн байгуулалтыг нэмэгдүүлнэ.	108	Баригдаж дуусаагүй барилга байгууламж, орон сууцыг үргэлжлүүлэн барьж ашиглалтанд оруулах	2017-2020	Сумын ЗДТГ, ГХБХБГ		Дуусаагүй барилга, орон сууцнууд ашиглалтанд орсон байна.	ГХБХБГ-тай хамтран дуусаагүй барилга байгууламжийн ажлыг түргэвчлэх албан бичиг хүргүүлснээр 25 айлын орон сууцны барилга, 640 хүүхдийн суудалтай сургууль, 2-р цэцэрлэг, Авзага зочид буудлын барилга зэрэг байгууламжууд үйл ажиллагаагаа эхэлж 640	100%

						хүүхдийн суудалтай сургууль болон 2-р цэцэрлэг ашиглалтанд орлоо.	
109	Гэр хороолол, орон сууцыг хэрэглээний халуун устай болгох ажлыг шат дараатай эхлүүлэх	2017-2020	Сумын ЗДТГ ГХБХБГ		Иргэдийн ажиллаж амьдрах орчин нөхцөл сайжирсан байна.	Булган сумын 14, 15, 12, 16, 17, 18, 22, 6, 7-р байруудын хэрэглээний халуун усны гадна өргөтгөлийг өмнөх жилүүдэд хийсэн. Энэ онд үйлдвэрийн зуухнаас Дэвшилт ХХК-ны байр хүртэлх шугамын засвар үйлчилгээг хийхээр орон нутгийн төсөвт тусгагдсан бөгөөд хэрэглээний халуун усны шугам нэмж суулгах саналыг аймгийн Засаг даргад тавьсан бөгөөд энэ ажилд нэмэлт хөрөнгө шаардлагатай байна.	40%
110	Булган хотын цэвэрлэх байгууламжийг өргөтгөх, шинээр төлөвлөж, шинэчлэх	2017-2020	Сумын ЗДТГ ГХБХБГ		Орон сууц, үйлдвэр, үйлчилгээний газруудын орчин нөхцөл сайжирна	Хугацаа болоогүй	
111	Гэр хорооллын айл өрхүүдийн хашаа гудамжны эмх цэгц, өнгө үзэмж, нийтийн эзэмшлийн талбайг иргэдийн санаачлага, оролцоонд тулгуурлан тохижуулах	2017-2020	ХБХ, ГХБХБГ, Сумын ЗДТГ		Жишиг хороолол, гудамж бий болж иргэдийн идэвх санаачилга нэмэгдсэн байна	“Цэмцгэр Булган” жилийн ажил зарлан удирдамжийг баг, байгууллагуудад хүргүүлэн ажиллаж 46 аж ахуй нэгжийг хамруулж тохижилт бүтээн байгуулалт, өнгө үзэмж сайжруулах ажлыг хийлээ. Айл өрхийн хүрээнд ч багууд идэвхитэй оролцсоноос 5 өрх тайлан ирүүлсэн. Мөн Булган сумын 1-р багт Хот байгуулалт мэдээлэл судалгааны төвийн 2,5 сая төгрөгийн дэмжлэгтэйгээр 1 гудамжийг жишиг болгох ажлыг иргэдийн санал санаачлагад тулгуурлан хийж хашаагаа цэгцэллээ.	100%
112	Наадмын талбайд шинэчлэл, засвар	2017-2020	ХБХ, ГХБХБГ, Сумын ЗДТГ		Өнгө үзэмж, багтаамж	Зураг төслийг Улаанбаатар хотын “ББСМО” ХХК хийсэн.	70%

	үйлчилгээ хийх				нэмэгдсэн байна.	Нийт төсөвт өртөг 1,5 тэрбум төгрөг бөгөөд /Барилга/ 800,0 сая төгрөгөөр гадна зам талбайг хийхээр төсөв гарсан. 2018 оны аймгийн орон нутгийн төсөвт 250,0 сая төгрөгний хөрөнгийг тусгууллаа.	
113	Булган сумын үерийн ус зайлуулах суваг, даланг шинэчлэх	2017-2020	ХБХ, ГХБХБГ, Сумын ЗДТГ		Үер, усны аюул ослоос урьдчилан сэргийлнэ.	1, 6-р багийн үерийн даланг шинэчлэх ажлыг “Туруун бүтээмж” ХХК 598,9 сая төгрөгөөр гүйцэтгэлээ.	100%
114	Үйлчилгээний байгууллагуудын гадна хаяг, өнгө үзэмжийг сайжруулах	2017-2020	Сумын ЗДТГ, Хувийн хэвшил		Хотын өнгө үзэмж сайжирна	“Цэмцгэр Булган” жилийн ажил төдийгүй аймгийн 80 жилийн ойн арга хэмжээтэй уялдуулан байгууллагууд гадна тохижилтын ажлыг гүйцэтгэсэн.	70%
115	Аймгийн 80 жилийн ойн хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудыг зохион байгуулах	2017-2020	АЗДТГ, Сумын ЗДТГ		Хотын өнгө үзэмж сайжирна	Аймгийн 80 жилийн ойн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 48 ажлыг эзэнжүүлсэн ба аймгийн ЗДТГ, ГХБХБГ-тай хамтран тооцоо, судалгаа, зураг төсвийг хийж хөрөнгө оруулагчдад хандаад байна. Уг төлөвлөгөөнд тусгагдсан авто зам, гэрэлтүүлэг, зогсоол зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэн.	100%
116	Соёлч өрх, баг, байгууллага шалгаруулах болзол зарлан дүгнэх	2016-2020	Сумын ЗДТГ ЭМГ, ӨЭМТ		Нийгмийн эрүүл мэндийн орчин бүрдсэн байна.	Цэмцгэр Булган уралдаанд 4 өрх, 1 орцны тайлан ирснийг ажлын хэсэг болон сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэлээ.	100%
117	САЦХүрээлэнгийн тохижилтийг шат дараатайгаар хийж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах	2016-2020	Сумын ЗДТГ, БСУГ, ТҮА		САЦХүрээлэнгийн тоглоомуудад урсгал засвар хийх, 2-р хэсгийн эскиз зургийг гаргах	Сумын САЦХ-д Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж урсгал засвар үйлчилгээг хийсэн бөгөөд 2018 онд тохижилтын ажлыг үргэлжлүүлэх 159,0 сая төгрөг тусгуулсан бөгөөд автомат тоглоом, ширээний	100%

							теннисний өрөө, мөсөн гулгуурын талбай байгуулах зэрэг үйл ажлуудыг зохион байгуулж үйл ажиллагааг нь тогтмолжуулах арга хэмжээг авч байна.	
3.4 Газар зохион байгуулалт, ашиглалт								
3.4.1 Иргэдийн оролцоотой газар зохион байгуулалтын төлөвлөлт хийж, газрын нөөцийг шинжлэх ухааны үндэслэлтэй зөв зохистой ашиглана	118	Үйлдвэржилтийн бүсэд газар авсан иргэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг жигдэрүүлэх, газар ашиглалтыг сайжруулах	2017-2020	СЗДТГ ГХБХБГ ХБХОБТХ		Үйлдвэржилтийн бүсийн ашиглалт сайжирсан байна. Иргэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа тогтмолжсон байна	Аймгийн ИТХ-ын 2017 оны 05-р сарын 09-ний өдрийн 75 дугаар тоогтоолын дагуу Булган аймгийн Булган Орхон сумын хил залгаа Домын дэвсгэг дэх үйлдвэрийн бүсийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг батлууллаа. Тус бүсэд ХАА-н үйлдвэрлэлийн бүсийн 48,6 га, барилгын материалын үйлдвэрлэлийн бүсийн 91,8 га газрууд тус тус хамрагдаж байгаа. 2017 он гарснаар тус бүсэд Булган аймгийн Засаг даргын 2017 оны 03-р сарын 21-ний өдрийн А/142 дугаар захирамжаар чацаргана, хагас боловсруулсан хүнсний ногооны үйлдвэр, арьс шир боловсруулах үйлдвэр, хүлэмжийн аж ахуй, барилгын материалын үйлдвэрлэл зэрэг зориулалтаар газрыг төсөл сонгон шалгаруулах журмаар олгохоор зарласан боловч оролцогч оролцоогүй.	100%
	119	Үйлдвэржилтийн болон шинэ суурьшлын бүсүүдэд инженерийн дэд бүтэц байгуулах	2017-2020	СЗДТГ ГХБХБГ ХБХОБТХ		Үйлдвэржилтийн болон шинэ суурьшлын бүсүүдийн цахилгаан, цэвэр усны хэрэгцээ хангагдана	Үйлдвэрийн бүсийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад холбогдох саналаа БХБ-ын яам, аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн бөгөөд 2018 оны төсөвт ТЭЗҮ боловсруулах хөрөнгө тусгагдсан.	70%
	120	Газрын	2017-	СЗДТГ		Газрыг иргэн	Булган сумын 2017 оны	100%

		шинэтгэлийн ажлыг эрчимжүүлж, иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад газар эзэмшүүлэх, газрыг иргэн бүрт үнэ төлбөргүй өмчлүүлэх ажлыг 25 хувиар өсгөж, эдийн засгийн эргэлтэнд оруулах боломжийг бий болгох	2020	ГХБХБГ		бүрт үнэ төлбөргүй өмчлүүлэх ажлыг 25 хувиар өсгөж, эдийн засгийн эргэлтэнд оруулсан байна.	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэхээр 539 нэгж талбар, хуучин хашааны газрыг өмчлүүлэхээр 151 нэгж талбар тусгагдсан. Шинээр өргөдлийг 205 нэгж талбарт хүлээн авч хуваарийн дагуу олголтыг бүрэн хийж 2015, 2016 онуудад газар олголт хийсэн боловч газраа баталгаажуулж аваагүй 334 нэгж талбарт газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлэн ажилласан. Хуучин хашааны газраа өмчилж авах үйл ажиллагааг идэвхижүүлэх үүднээс аймгийн Засаг даргын захирамжаар “Газар таны өмч” аяны хүрээнд баг тус бүр дээр ажиллаж 62 өргөдлийг хүлээн авч шийдвэрлэлээ. Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын захирамжаар 183 иргэн газраа өмчилж баталгаажуулаад байна. Газрын тухай хуулийн дагуу иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 6 дугаар баг Жаргалантын аманд 20 нэгж талбар, 6 дугаар баг Залуус хороололд 11 нэгж талбарт газар эзэмших эрхийг сумын Засаг даргын А/117, аймгийн Засаг даргын А/492 дугаар захирамжаар, төрийн үйлчилгээний зориулалтаар 8 нэгж талбар төлөвлөгдсөнөөс 7 нэгж талбарыг сумын Засаг даргын А/148 дугаар
--	--	--	------	--------	--	---	---

						<p>захирамжаар, үйлчилгээний зориулалтаар 1 нэгж талбар орон сууцны зориулалтаар 1 нэгж талбар, ус дамжуулах төв байгуулахаар 3 нэгж талбар төлөвлөгдсөнийг газар эзэмших эрхийг аймгийн Засаг даргын А/491 дугаар захирамжаар баталгаажуулсан.</p> <p>Жимс жимсгэнэ тариалах зориулалтаар 3 нэгж талбарт 18 га газар төлөвлөгдсөнийг 12 бүлэгт газар олголтыг бүрэн хийсэн.</p> <p>ХАА-н үйлдвэржилт, Барилгын материалын үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 3 нэгж талбарт төсөл сонгон шалгаруулалт, дуудлага худалдааг аймгийн Засаг даргын А/142 дугаар захирамж, сумын Засаг даргын А/11, А/149 дугаар захирамжаар зарласан боловч оролцогч оролцоогүй учраас хэрэгжилт 50%-ийн гүйцэтгэлтэй биелэгдсэн.</p> <p>Булган сум 5 дугаар баг Булган МЭЭЖ ОНӨХК-ний урд талд авто зогсоол барих төлөвлөгөөг аймгийн ОНХөгжлийн сангийн хөрөнгөөр хийлээ.</p>	
	121	Газрын төлбөрийн орлогын зохих хувийг газрыг хамгаалах, нөхөн сэргээх болон газар зохион байгуулалтын бусад арга хэмжээнд зарцуулах асуудлыг жил бүр төлөвлөн	2017-2020	СЗДТГ ГХБХБГ	Хуулийн хэрэгжилт хангагдана	<p>Газрын төлбөр 25.1 сая, дуудлага худалдаа 8 сая төгрөг төлөвлөгдсөнөөс газрын төлбөр 18,5 сая төгрөг төвлөрөөд байна.</p>	100%

		баталгаажуулж хэрэгжилтийг ханган ажиллах						
	122	Бунхан толгойн тохижилтийн ажлыг зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэх	2017-2019	СЗДТГ ГХБХБГ		Бунхан толгойн тохижилтийн ажлыг дуусгаж орон нутгийн иргэд, гадна, дотны зочид жуулчдыг татсан цогцолбор болсон байна.	Хувийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэн ашиглах иргэн, аж ахуйн нэгжүүдэд санал тавьж байгаа боловч төдийлөн үр дүнд хүрэхгүй байна. Дахин төлөвлөлт хийж үйл ажиллагааг өргөтгөх шаардлагатай байна.	0%
3.5 Мэдээлэл, технологи								
3.5.1 Хүн амын мэдээллийн эрэлт хэрэгцээг хангахуйц өрсөлдөөнт хэвлэл мэдээлэл, харилцаах олбоо, интернетийн үйлчилгээг дэмжинэ.	123	Утасгүй интернетийн орчин бий болгох	2017-2020	Сумын ЗДТГ, Хувийн хэвшил		Олон нийтийн сүлжээний үнэгүй орчинтой болно.	Цогт Хунтайжийн талбай болон сансар 1 сааданд утасгүй интернетийн бүс болгох саналыг аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн. Мөн Залуучуудын холбооноос Цогт Хунтайжийн талбайг сандал бүхий утасгүй интернетийн бүс бий болгох төслийг дэмжиж Засаг даргын нөөц хөрөнгөөс 0,7 сая, айл өрхийн өндөр хурдны интернетээр хангах төслийг СХС-ийн 20,0 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус дэмжсэн.	100%
	124	Орон нутгийн мэдээллийн сувгийг дэмжих	2017-2020	Сумын ЗДТГ, Хувийн хэвшил		Төрийн үйлчилгээний мэдээлэл түргэн шуурхай иргэдэд хүрдэг болсон байна.	"Сайхан Монгол" телевизийн үйл ажиллагааг дэмжиж сум хөгжүүлэх сангаас 20,0 сая төгрөгийн зээл олгосны зэрэгцээ бартерийн нөхцөлөөр үйл ажиллагаа явуулах байраар хангасан.	100%
ДӨРӨВ. БАЙГАЛЬТАЙГАА ЗОХИЦОН ОРШИХ НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
4.1 Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого								
4.1.1 Усыг хэмнэлттэй ашиглаж, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангаж,	125	Гүний худгуудын ус нөөцлөх савыг бүрэн шинэчилж, ундны усыг улирал бүр тогтмол шинжилгээнд	2016-2020	БОАЖГ ЗДТГ			Ундны усны усан сангуудын ус нөөцлөх савыг бүрэн шинэчилсэн. МХГ-аас ус нөөцлөх савны усны дээжийг улирал тутам шинжилгээнд хамруулж хэвшсэн.	100%

ундны цэвэр усны эх үүсвэрийн хамгаалалтыг сайжруулна.	126	хамруулж байх Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тогтоож, тэмдэгжүүлэх, хамгаалалтын дэглэмийг мөрдүүлэх	2016-2020	БОАЖГ ЗДТГ		Ундны усны эрүүл ахуй, аюулгүй байдал хангагдана	Хамгаалалтын бүс тогтоосон ИТХ-ын тогтоолыг хэрэгжүүлж дэглэмийг мөрдүүлэх хяналт шалгалтын 2 сарын ажлыг Цагдаагийн газрын дарга, Булган сумын Засаг даргын хамтарсан удирдамжаар зохион байгуулж, 4 зөрчил илрүүлэн холбогдох хуулиар захиргааны арга хэмжээ авч шийдвэрлэлээ. Хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх ажлыг Хануй голын захиргаагаар 10ш самбар Ачуут, Зүүн түрүүний голын сав газарт тогтоосон зай хэмжээнд байрлуулсан.	70%
	127	Голын эхийг сэргээн засварлаж, бүрэн хашиж хамгаалах	2016-2020	БОАЖГ ЗДТГ		Усыг бохирдолоос хамгаалж, хуулийн хэрэгжилт хангагдана	Сумын нутаг дэвсгэр дэх хашиж хамгаалсан булаг шандны судалгаа гаргаж, Ачуутын голын эхийг шинээр хашиж хамгаалах саналыг БОАЖГ-т хүргүүлсэн. Ирэх онд мөн 2 булгийн эхийг сэргээн заварлах саналыг гаргаад байна.	40%
4.1.2 Агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх, бууруулах технологийг дэмжинэ арга	128	Агаарын бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2017-2020	БОАЖГ ЗДТГ		Голын эхийг хамгаалж, усны ундарга нэмэгдэнэ.	Бүрэн шаталттай зуухны хэрэглээ болон шахмал түлшний хэрэгцээг дэмжих, шөнийн тарифаар цахилгаан халаагуур хэрэглэх талаар иргэдэд сурталчилах, уурын зуухны янданд шүүлт тавих, стандартын шаардлага хангасан нүүрс хэрэглэх талаар Булган Мээж ОНӨХК-д шаардлага тавин ажиллаж байна.	70%
4.1.3 Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын менежментийн	129	Хязгаарлагдмал нөөц баялагаа зохистой ашиглах, орчны бохирдолыг багасгаж, хог	2016-2020	ЗДТГ ТҮА		Экологийн боловсрол нэмэгдэж, зөв дадал зуршил ухамсар	Хог хаягдлаа цэвэрлэх аяныг 2 үе шаттай зохион байгуулж 112 байгууллагын 961 иргэн хамрагдаж гэр хороолол, нийтийн эдэлбэр газрын	70%

<p>төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэн, эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээж, байгаль орчны бохирдлыг бууруулна.</p>		<p>хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал зуршил суулгах сургалт сурталчилгаа хийх</p>				<p>төлөвшинө.</p>	<p>1033,5 мз, голын сав газрын болон хогийн цэгийн орчим 20 га-д тархсан 269 сэг зэм, 2751 мз хог хаягдлыг 1,2 га-д цуглуулан булж ландфилл хийж орчны бохирдлыг багасгасан. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах мэдээлэл сурталчилгааг хог ачих тухай бүрд хогны байцаагч нар байнга хийж байна. Мөн хог хаягдлын байгаль дахь бохирдлын хугацааны талаар ЭӨЦС, МСҮТ-ийн 156 сурагчдад мэдээлэл сурталчилгааг хийсэн. Хог ангилан ялгах хогийн савыг үргэлжлүүлэн 400 ширхэгийг хийж 6, 3, 5-р багийн айл өрхөд олголоо.</p>	
	130	<p>Булган сумын агаар, хөрсний судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэх</p>	2016-2020	ЗДТГ УЦУОША		<p>Агаарын бохирдуулагчийн эх үүсвэрийг тогтооно</p>	<p>УЦУОШГ нь Булган сумын агаар, хөрсний шинжилгээг тогтмол хийж байна. Агаар бохирдуулагчийн 2017 оны тооллогыг хийж гүйцэтгэв.</p>	100%
	131	<p>Айл өрх, аж ахуйн нэгжүүдийн сэргээгдэх эрчим хүч болон хийн түлшний хэрэгцээг бодлогоор дэмжих</p>	2016-2020	ЗДТГ		<p>Агаарын бохирдол багасна</p>	<p>Хийн түлшний хэрэглээг дэмжиж, “Дашваанжил” ХХК-д газын хийн ШТС-ын зориулалтай газар олгож бодлогоор дэмжлээ.</p>	40%
	132	<p>БОНБҮнэлгээ хийлгэсний дараа газар эзэмшүүлэх гэрээ гэрчилгээг олгож хэвших</p>	2016-2020	ЗДТГ		<p>Байгаль орчин дахь сөрөг нөлөөлөл багасаж, хуулийн хэрэгжилт сайжирна.</p>	<p>Газар эзэмшүүлэх шийдвэрийг үндэслэн БОНБҮ хийлгэсний дараа гэрээ байгуулж, гэрчилгээ олгох хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагыг 7 ААНБ-д хүргүүлж, 5 ААНБ хийж, хяналт тавин хэрэгжүүлж байна.</p>	70%
	133	<p>Хог хаягдлыг дахин боловсруулах цехийн үйл ажиллагааг</p>	2016-2020	ЗДТГ ТҮА		<p>Байгаль дахь хог хаягдал багасаж, ажлын байр</p>	<p>Хог хаягдлыг дахин боловсруулах цехийг ашиглалтанд бүрэн оруулах шаардлагатай байгааг</p>	100%

		жигдрүүлэх				нэмэгдэнэ.	аймгийн удирдлагуудад танилцуулж саналаа хүргүүлсний үндсэн дээр байнгын 2 орон тоотой байхаар цалингийн сангийн асуудлыг шийдвэрлүүлсэн.	
.1.4 Ойн сангийн хамтын эзэмшлийн менежментийг сайжруулж, ойжуулалт хийх, ойг нөхөн сэргээх ажлыг өргөжүүлж, төв суурингийн ногоон байгууламжийн хэмжээг жил бүр нэмэгдүүлнэ	134	Мод үржүүлгийн газрыг 3-аас доошгүйг байгуулж, жилд 2-оос доошгүй удаа мод тарих хөдөлгөөн өрнүүлэх	2016-2020	ЗДТГ ОЙН ААНБ		Тарьц суулгацын хэрэглээ хангагдаж ногоон байгууламж нэмэгдэнэ.	Сумын ойн мэргэжлийн 3 байгууллага, нэг нөхөрлөлд мод үржүүлгийн 1,5 га газар олгоод байна. Сумын Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/94 дүгээр захирамж, 01/257 албан тоотын хэрэгжилтийг хангуулж 2 удаа зохион байгуулж, хавар 1368 иргэн хамрагдаж 2573 ш мод бут, намар 107 ААНБ-ын 860 иргэн 1221 ш мод бут тарьсан. Мөн “Чацаргана” төслийн хүрээнд 261 иргэн 42,2 га-д 38334 ш чацаргана тариалсан.	70%
	135	Модыг орлох шахмал түлшний үйлдвэрлэлийг дэмжин өргөжүүлэх	2016-2020	ЗДТГ		Модны зохистой хэрэглээ нэмэгдэж, агаарын бохирдол буурна.	“Билгүүн дэлгэрэх” ХХК-ийн шахмал түлш 10 тн-ыг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлээд байна. Айл өрхийн шахмал түлшний хэрэглээг дэмжих бодлого барьж, сургалт сурталчилгаа явуулж байна.	100%
	136	Орон нутгийн хамгаалалттай газрын тэмдэг тэмдэглээг хийж мэдээллийн самбартай болгох	2016-2020	БОАЖГ ЗДТГ		Хууль бус үйл ажиллагаа хязгаарлагдан а	Орон нутгийн хамгаалалттай газрын хамгаалалтын дэглэмийг харуулсан самбарыг аялал жуулчлал, амралт зуслангийн замын орчимд байрлуулж хамгаалалтын дэглэмийг тухайн нутаг дэвсгэр дэх идэвхтэн байгаль хамгаалагч нарын өдөр тутмын хяналтаар хэрэгжүүлж байна.	40%
	137	Үерийн усны нөлөө болон барилгын материалд	2016-2020	БОАЖГ ЗДТГ		Байгалийн унаган төрх сэргээгдэнэ.	Хуучин карьерыг “Булган АЗЗА”, “Сэлэнгэ-Есөн Эрдэнэ” ХХК-д авто замын	100%

		ашиглаж эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх /Хадан хошууны хуучин карьер, Хөрөө рам гм/				Аюулгүй орчин бүрдэнэ.	даланд ашиглуулан дараа нь техникийн нөхөн сэргээлт хийлгэх гэрээ байгуулан нөхөн сэргээлтийг гүйцэтгүүлсэн.	
	138	Байгаль орчны мэргэжилтнийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2016-2020	БОАЖГ ЗДТГ		Хяналт шалгалтын ажил эрчимжиж, үр дүнд хүрсэн байна.	Унаа, хувцас, тээврийн хэрэгсэл зогсоох зориулалтын улаан гэрлээр хангагдсан.	100%
4.2. Аялал жуулчлал								
4.2.1. Булган сумын аялал жуулчлалын хөтөлбөр, маршрутыг нарийвчлан тогтоож, сумын аялал жуулчлалын лавлах, видео танилцуулга, цахим хуудас нээж сурталчилна.	139	Аялал жуулчлалын үзвэрийн танилцуулга гаргах	2017	Сумын ЗДТГ, БОАЖГ		Жуулчдыг татах мэдээлэл мэдээлэлтэй болно	Сумын аялал жуулчлалын үзвэрийн танилцуулгын эх бэлтгэлийг хийсэн.	40%
	140	Аялал жуулчлалын мэдээллийг цэг, самбар байршуулах	2017-2018	Сумын ЗДТГ, БОАЖГ		Гадаад, дотоодын жуулчид нэмэгдэнэ	Эхийг бэлтгэн хэвлэлтэнд өгөөд байна.	40%
4.2.2 Орон нутгийн онцлог бүхий аялал жуулчлалын эвент /цогц/ үйл ажиллагааг аялал жуулчлалын байгууллагуудтай хамтран зохион байгуулж, аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, сурталчилгааг эрчимжүүлнэ.	141	Диваажин сүм, цагаан суваргын түүх домгыг түшиглэсэн эвент арга хэмжээ зохион байгуулах	2017-2020	Сумын ЗДТГ, БОАЖГ		Дотоод, гадаадын жуулчдын тоо нэмэгдэнэ.	Диваажин сүм, Цагаан суваргыг түшиглэн байгуулж буй Бурхан багшийн энергийн цэцэрлэгт хүрээлэнд жил бүр уламжлал болгон зохион байгуулах Шагайн харвааны тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Диваажин сүмийг үргэлжлүүлэн засах гүйцэтгэгчийг БСУЯаманд тодруулж гэрээг аймгийн Засаг даргатай хийлээ.	100%
	142	Аялал жуулчлалын маршрут дагуу үйлчилгээний төвүүдийг байгуулахыг дэмжих	2017-2020	Сумын ЗДТГ, БОАЖГ		Ажлын байр нэмэгдэнэ.	Булган Хөвсгөл чиглэлийн зам дагуу худалдааны төв барих 1 аж ахуйн нэгжийн саналыг дэмжиж стандартын зөвлөгөө өгч, 1 иргэнд дуудлага худалдаагаар газрын асуудлыг нь шийдвэрлээд байна Улаанбаатар-Хөвсгөл-	100%

							Улаанбаатар хотруу чиглэн аялж буй гадаад, дотоодын жуулчдыг татах, орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Булган-Хөвсгөлийн авто замын дагуу “Тэмээн толгой” гэдэг газар 1 га газарт түр буудаллах цэг байгуулахаар газрын асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд энэ онд туршилтаар ААН, иргэдэд түр ашиглуулахаар төлөвлөж, цаашид тус газарт орон нутгийн онцлог, зан заншлыг харуулсан үйлчилгээг бий болгох зорилго тавин ажиллаж байна.	
	143	Байгаль орчинд сөрөг нөлөөгүй эко хэрэглээг дэмжих	2017-2020	Сумын ЗДТГ, БОАЖГ		Байгаль орчинд үүсэх сөрөг нөлөөлөл багассан байна.	Тодорхой санал ирээгүй	0%
4.2.3 Түүх, соёлын дурсгалт газруудыг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	144	Диваажин сүмийг сэргээн засварлах ажлыг дуусгах	2017-2020	Сумын ЗДТГ, ГХБХБГ БОАЖГ		Түүхэн дурсамжийг сэргээх	2017 онд улсын төсвөөс 180,0 сая төгрөг батлагдаж далангийн овоолгын ажил хийгдэх ба холбогдох яаманд гүйцэтгэгчийг шалгаруулж, гэрээг аймгийн Засаг даргатай байгуулсан.	70%
	145	Хотын өнгө төрхийг тусгасан бэлгэдлийн хаалгатай болох	2017-2020	Сумын ЗДТГ, ГХБХБГ		Орон нутгийн онцлогийг гадаад, дотоодын жуулчдад сурталчилна	Хөвсгөл чиглэлийн авто зам дээр хүндэтгэлийн хаалга барихаар Эвсэг констракшн ХХК санал ирүүлснийг дэмжиж газрын асуудлыг нь шийдвэрлэсэн боловч хөрөнгийн асуудал шийдэгдээгүй.	40%
	146	Бунхан толгойн алдартнуудын хөшөө цогцолборыг дуусгах	2018	Сумын ЗДТГ, ГХБХБГ БОАЖГ		Орон нутгийн онцлогийг гадаад, дотоодын жуулчдад танин	Уралдаан зарласан боловч шаардлагад нийцсэн материал ирээгүй бөгөөд хийгдэх хугацаа болоогүй.	

						мэдүүлэх		
	147	Цагаан хаалгыг сэргээн засварлах	2018	Сумын ЗДТГ, ГХБХБГ БОАЖГ		Орон нутгийн онцлогийг гадаад, дотоодын жуулчдад танин мэдүүлэх	Хугацаа болоогүй.	
	148	Дугуйн жишиг зам байгуулах	2017-2020	Сумын ЗДТГ, ГХБХБГ БОАЖГ		Явган болон дугуйн аялалыг хөгжүүлэх боломж бүрдэнэ.	САЦХүрээлэнд дугуйн зам барихаар төлөвлөсөн бөгөөд материалын зардлыг тооцож ГХБХБГ-т хүргүүлсэн. Хөрөнгийн асуудал шийдэгдээгүй.	40%
	149	Бурхан багшийн энергийн цэцэрлэгт хүрээлэнгийн ажлыг дуусгах	2017-2020	Сумын ЗДТГ, Булган сумын нутгийн зөвлөл, хувийн хэвшил		Иргэдийн чөлөөт цагаа өнгөрөөх цэцэрлэгт хүрээлэнтэй болсон байна.	Булган сумын нутгийн зөвлөл, иргэдтэй хамтран мод тарьсан ба Бурхан багшийн бага насны дүрийг байрлуулсан. Мөн явган хүний замыг хийж Баян-Агт сум тохижилтын ажлыг хийж гүйцэтгээд байна.	100%

ТАВ. ИРГЭНД ЭЭЛТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО.

5.1.1 Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй болгож, иргэдийн мэдээлэл, үйлчилгээ авах боломж, нөхцөлийг сайжруулна.	150	Төрийн байгууллагын цахим үйлчилгээг нэмэгдүүлэх, цахим мэдээллийг иргэдэд хүргэх арга замыг хэрэгжүүлэх	2016-2020	Сумын ЗДТГ		Иргэдэд мэдээлэл шуурхай хүрдэг болно.	Ажилтнуудын цаг бүртгэл, ирсэн явсан бичиг, захирамж, тушаалыг цахим санд бүртгэдэг бөгөөд газар, нийгмийн халамж, иргэний бүртгэл мэдээллийн үйлчилгээ, сумын бүх иргэдийн бүртгэл, мэдээллүүдийг цахим санд байршуулан түүнээс холбогдох үйлчилгээг үзүүлж лавлагаа мэдээлэл олгож байна. 2017 оны 1 дүгээр улирлаас эхлэн газар эзэмшүүлэх дуудлага худалдааг газрын цахим бирж буюу MLE.mn сайтаар явуулж эхэлсэн ба Булган суманд газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2 дугаар баг "Г" хэсэгт байрлах Орхон	100%
---	-----	--	-----------	------------	--	--	--	------

						<p>аймаг орох зам дагуу үйлчилгээний зориулалтаар олгох 1200м2 газрын дуудлага худалдааг зарласан. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газрын мэдээллийн нэгдсэн сан Ланд менежер программ хангамжаар газрын лавлагаа, эзэмшил, өмчлөлийн бүртгэлийн эрх үүсгэх үйл ажиллагааг явуулж, мэдээллийн нэгдсэн санд холбоод байна. Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийг нэгдсэн санд бүртгэж лавлагаа мэдээлэл гарган үйлчилж байна.</p> <p>Мөн байгууллагын удирдлагын ABLE программыг үйл ажиллагаандаа ашиглаж хэвшсэн нь аливаа ажлыг шуурхай хурдтай зохион байгуулахад үр дүнгээ өгсөөр байна.</p> <p>Иргэдэд хүргэх аливаа мэдээллийг сумын цахим хуудсанд байршуулах, санал авах ажлыг хийж байна. Тухайлбал нийтлэг хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахын өмнө цахимд 30 хоног байршуулан санал авч байна.</p>		
	151	Албан ёсны цахим хуудасны тухай баяжилтыг бүр хийх	2016-2020	Сумын ЗДТГ		Мэдээллийн хүртээмж сайжирна.	Байгууллагын цахим хуудасны танилцуулга, цаг үеийн мэдээлэл, тогтоол, захирамж, өргөдөл гомдол, харьяа байгууллагуудын мэдээлэл, сэрэмжлүүлэг мэдээлэл зэргийг тогтмол баяжуулан мэдээлж байна.	100%
	152	Нэг цонхны	2016-	Сумын ЗДТГ		Төрийн	Одоо сумын НЦҮ-д газрын	100%

		үйлчилгээ"-ний цар хүрээг нэмэгдүүлж, "Угтах-үдэх үйлчилгээ"-г хэвшүүлэх	2020			үйлчилгээний цар хүрээ нэмэгдэж шуурхай байдал хангагдана.	даамал 2, улсын бүртгэлийн ажилтан, нийгмийн халамжийн 2 мэргэжилтэн, хөдөлмөр эрхлэлт хариуцсан 1 мэргэжилтэн, өргөдөл хүсэлт- мэдээлэл зөвлөмж хариуцсан ажилтан нийт 7 ажилтан 5 төрлийн үйлчилгээг иргэдэд хүргэж үйл ажиллагааг тогтворжуулсан ба иргэдэд хүргэх үйлчилгээг ойртуулахаар Нотариатчийг тус тамгын газрын байранд ажиллуулж байна. Үйлчилгээ авахаар ирж байгаа иргэдэд зориулан угтах үйлчилгээг жижүүрүүдэд хариуцуулан гүйцэтгүүлж хэвшлээ.	
	153	Тохижилт үйлчилгээний ангийн бүтэц орон тоог нэмэгдүүлэн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	2017-2020	Сумын ЗДТГ СТСХ		Хотын тохижилт соёлжилтын ажлын чанар сайжирна.	ТҮА-ийн бүтцэд 7 ажилтны цалингийн санг аймгийн ИТХ-аар батлуулсан.	100%
	154	Үйл ажиллагааны мэдээллийг орон нутгийн мэдээллийн хэрэгслээр иргэдэд хүргэх	2016-2020	Сумын ЗДТГ		Мэдээллийн хүртээмж нэмэгдэнэ.	Байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг байгууллагын цахим хуудас, нүүр ном, Булганы мэдээ сонин, Булган сум мэдээллийн хуудас, Эх орон-21 сайт, урсдаг зарын самбар зэрэг мэдээллийн хэрэгслээр тухай бүр иргэдэд хүргэж байна.	100%
	155	Багийг чадавхижуулан Багийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг тогтворжуулах	2016-2020	Сумын ЗДТГ		Жишиг багт нийцсэн хөгжлийн төвүүд бий болж, багийн иргэд үйлчлүүлэх таатай орчин бүрдсэн	Булган сумын 1, 4, 6-р багууд багийн хөгжлийн төвтэй болж багийн Засаг дарга, хэсгийн байцаагч, өрхийн эмч нар үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд хэсгийн ахлагч нарын цуглаан, сургалт мэдээлэл хийх, биеийн тамирын болон	100%

						байна.	цэнгээнт уралдаан тэмцээн явуулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.	
	156	Төрийн албанд мэргэшсэн албан хаагчдыг бүрдүүлэх зорилгоор ажлын байрны тодорхойлолтыг нягтлан шалгаж ажил үүргийн хуваарийг оновчтой болгон төрийн албаны хүний нөөцийг хөгжүүлж байгууллагын чадавхийг бэхжүүлэх	2016-2020	Сумын ЗДТГ		Төрийн албаны үйл ажиллагааны үр нөлөө нэмэгдсэн байна.	Төрийн албаны сул ажлын байр гарсан тохиолдолд хүний нөөцөд бүртгэлтэй болон уг ажлын байрны шалгуурт заасан мэргэжилтэй иргэнийг сонгон авч ажиллуулж байна. Мөн ажилтнуудыг аймаг, орон нутгаас зохион байгуулж байгаа урт, богино хугацааны сургалтуудад тухай бүр хамруулан ур чадварыг эзэмшүүлэн чадавхижуулж байна.	100%
	157	Ажил үйлчилгээний онцлогт тохирсон соёл, хандлагыг хэвшүүлэх	2016-2020	Сумын ЗДТГ		Үйлчилгээг эрхэмлэсэн төрийн алба бэхэжсэн байна.	“Ажилтны харилцааны соёл, хувцаслалтанд тавих шаардлага” стандартыг батлуулан мөрдөхөөс гадна “5С”-г нийт ажилтнууд үйл ажиллагаандаа хэвшил болгосон.	100%
	158	Тамгын газрын барилгад их засвар хийх	2016-2020	Сумын ЗДТГ		Төрийн албан хаагчынажил лах нөхцөл сайжирсан байна.	Булган сумын ЗДТГ-ын барилгад гадна засварын ажлыг “Хонгорын чулуу” ХХК-иар 96,7 сая төгрөгийн төсөвтэйгээр хийлгэлээ. Мөн төсвийн хөрөнгө, ажилтнуудын өөрсдийн санаачлага дэмжлэгээр зарим урсгал засварыг хийж ажиллах нөхцөлийг тодорхой хэмжээгээр бүрдүүлсэн.	100%
5.1.2 Хууль эрх зүй, батлан хамгаалах, аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлж, нийтийн албаны ёс зүйг өндөржүүлэн, сахилга хариуцлагыг	159	Батлан хамгаалах үйл ажиллагааг иргэдэд нээлттэй сурталчлан, дайчилгааны төлөвлөгөө, цэргийн бүртгэл судалгааг бодитой	2016-2020	Сумын ЗДТГ		Иргэдийн мэдлэг мэдээлэл сайжирна.	Сумын Засаг даргын захирамжаар 2017 оны ээлжит цэрэг татлагыг 2 үе шаттай зохион байгуулсан. Аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний дагуу эхний 1-р ээлжийн цэрэг татлагаар 28	100%

дээшлүүлнэ		төлөвлөн ажиллах					залууг тэнцүүлсэн. Энэхүү арга хэмжээг олон нийтэд удаа дараа хэвлэл мэдээллийн хэрэгслээр 14 хоногийн хугацаатай мэдээлж ажилласан бөгөөд нийт 285000 төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан. Цэргийн бүртгэл судалгааг тухай бүр хуулийн хүрээнд бүртгэл хөтлөн ажиллаж байгаа бөгөөд хугацаандаа бүртгэлд хамрагдаагүй 4 иргэнийг тус бүр 10 мянган төгрөгөөр торгож хүү торгуулийн дансанд төвлөрүүлсэн. Сумын дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэн тодотгосон.	
	160	Цэргийн жинхэнэ алба болон гэрээт цэрэг, цэргийн дүйцүүлэх албаны үйл ажиллагааг зохион байгуулах	2016-2020	Сумын ЗДТГ		Хуулиар хүлээсэн үүрэг биелэгдэнэ.	Цэргийн албан тухай хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу сумын ИТХ-ын тэргүүлэгчдээр цэргийн албыг дүйцүүлэн хаахаар хүсэлт ирүүлсэн 4 иргэний өргөдлийг хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, албыг аймгийн цэргийн штабтай хамтран хаалгаж байна. Дүйцүүлэхээр алба хаагчдыг хуулийн хүрээнд олон нийтийн болон шаардлагатай ажилд дайчлан ажиллаж, ажилласан бүртгэлийг хөтөлж байна.	100%
	161	Орон нутгийн чанартай авто замын уулзваруудад тэмдэг, тэмдэглэгээ тавих ажлыг	2016-2020	Сумын ЗДТГ		Эрсдлээс сэргийлнэ.	Авто замын сангийн хөрөнгөнд тусгагдсан бөгөөд авто замын бродюр, хэвтээ тэмдэглэгээг тодруулах, төв гудамжны босоо тэмдгийг шинэчлэх ажил хийгдсэн.	100%

	162	үргэлжлүүлэн хийх	2016-2020	Сумын ЗДТГ		Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх арга хэмжээ авагдсан байна.	“Эрүүл ирээдүй” хөтөлбөрийн сургалтын багаас зорилтот бүлгийн иргэдэд архи мансууруулах бодис болон архинд донтох өвчин, иргэний эрх, эрх чөлөөний тухай агуулга бүхий сургалтыг Цагдаагийн газрын хэсгийн байцаагч болон Хүний эрхийн үндэсний комиссын Булган аймаг дахь ажилтан Д.Мөнхсайхан нартай хамтран зохион байгууллаа. Энэхүү сургалтанд 6 багийн зорилтот бүлгийн 30 гаруй иргэн хамрагдлаа. Мөн сургуулийн нийгмийн ажилтнууд 7 хоног бүрийн 1 өдрийг сонгон сургалтуудыг үе шаттай зохион байгуулж байна. Өсвөр насны хүүхэд багачуудыг хорт зуршилд автахгүй байх, эрсдэлт хорт зуршлаас өөрийгөө хамгаалах, зөв дадал хэвшилд суралцах, өөрийн гэсэн үзэл бодолтой байх, тамхинаас хамааралтай иргэн болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Тамхины хор хөнөөл” сэдэвт сургалтыг зохион байгуулан 8-р ангийн 3 бүлгийн 77 сурагчаас 64 сурагч буюу 83 хувийг хамрууллаа. “Эрүүл ирээдүй” хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа томоохон ажлын нэг нь хүчирхийлэлд өртсөн иргэдэд нийгмийн үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байр бөгөөд уг байранд 2017 онд эрх нь	100%
		“Эрүүл ирээдүй” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх						

							зөрчигдсөн 3 эмэгтэй, насанд хүрээгүй 10 хүүхдийг хүлээн авч, нийгмийн ажилтныг 24 цагаар ажиллуулан нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэн холбогдох байгууллагуудтай хамтран хүүхдийн эрхийг хамгаалах, зөвлөгөө мэдээлэл өгөх зэрэг ажлыг зохион байгуулсан байна.	
5.1.3 Аливаа шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахад иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоонд тулгуурлан, ардчилсан удирдлагын тогтолцоог хэрэгжүүлнэ.	163	Нийтлэг хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахдаа иргэний танхимаар хэлэлцүүлж, иргэд, ИНБ-ын саналыг авч байх	2016-2020	Сумын ЗДТГ		Шийдвэр гаргах түвшинд иргэний оролцоо нэмэгдэнэ.	2017 он гарсаар Булган сумын ЗДТГ, сумын ИТХ-ын ажлын алба, холбогдох мэргэжилтнүүд хамтран дараахь хэлэлцүүлгүүдийг хийж иргэдээс гаргасан саналыг шийдвэрт тусган ажиллаж байна. Иргэдийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, орон нутгийн төсвийг бүрдүүлэх зорилгоор айл өрх бүрт хөтлөгдөх “Иргэний үүргийн дэвтэр”-ийн төсөл, “Цэмцгэр Булган” уралдааны удирдамж, “Сумын Засаг даргын шагналын журам”, сумын мал бүхий иргэдийг оролцуулан “Суурин мал маллагааны бүсэд баримтлах журам”, “Ил зайдгай худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд түр зөвшөөрөл олгох журам”-ын хэлэлцүүлэг хийх, цахим хуудсанд байршуулан санал авах зэрэг ажлыг тус тус хийж цаашид анхаарах асуудлын талаар санал солилцох, саналыг шийдвэрт тусгах зэрэг арга хамжээг авлаа.	100%
	164	ИНБ,ТББ-ын үүсгэл санаачилгыг дэмжиж, төрийн	2016-2020	Сумын ЗДТГ		Төр, иргэний харилцан итгэлцэл	Сумын Засаг даргын 2014 оны А/37 тоот захирамжаар ТББ-аар гүйцэтгүүлэх ажил	70%

		зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх				сайжирсан байна.	үйлчилгээний жагсаалтыг батлан мөрдөж тамгын газрын үйл ажиллагааны үнэлгээний ажил, бүх төрлийн сургалт сурталчилгааны ажил, бүтээн байгуулалтын ажил, бүтээн байгуулалтын ажилд хяналт үнэлгээ хийх ажил, ажлын хэсгийн бүрэлдэхүүн оруулах, зарим төрлийн тэмцээн уралдаан зэрэг ажлыг хамтран зохион байгуулдаг.	
5.1.4 Гадаад харилцаа хамтын ажиллагааг боломжит чиглэлээр хөгжүүлж, хамтран ажиллана.	165	Хөрш зэргэлдээ орнуудын хотуудтай олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн хамтран ажиллана.	2016-2020	Сумын ЗДТГ		Хамтын ажиллагаа хөгжсөн байна.	Сумын Засаг дарга Япон улсын Морие хотод айлчилж сувилагч, сурагч солилцооны талаар хамтран ажиллахаар туршлага судлаад ирсэн. Мөн ОХУ-ын Улан-Үдэ хотын багшийн коллежтэй хамтран ажиллаж Булган аймгаас 30 гаруй оюутныг сургаж байна. Энэ ажлын хүрээнд Булган сумын сургууль цэцэрлэгүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага судлах зорилгоор 44-р цэцэрлэг, дунд сургуулийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судлах ажлыг НСАХМ Л.Туяа болон цэцэрлэг, сургуулиудын удирдлагуудын бүрэлдэхүүнтэй баг яваад ирсэн байна.	100%